



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/29

Шивээговь сум

Сэг зэм устгалын ажил зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/52 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Мал эмнэлгийн ариун цэвэр, халдваргүйтгэл, сэг зэм устгалын ажлыг 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс 03 дугаар сарын 07-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Мал эмнэлгийн ариун цэвэр, халдваргүйтгэл, сэг зэм устгалын ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Мал эмнэлгийн ариун цэвэр, халдваргүйтгэл, сэг зэм устгалын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

С.Отгонбаатар

(Сумын 2 дугаар багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Ш.Буяннэмэх

(Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч)

О.Отгонбаяр

(Байгаль хамгаалагч)

Д.Эрдэнэтулга

(Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)